



## **МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ГИШҮҮНИЙ ТАТВАРЫН ЖУРАМ**

**Улаанбаатар хот  
2014 он**

## МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 1 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7, 48.10, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.6 дугаар зүйлийн 4, 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус удирдлага болгон Хуульчдын холбооны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.9.12, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 2.6 дугаар зүйлийн 5, 4.1 дүгээр зүйлийн 1, 4.13 дугаар зүйлийн 1.14 дэх заалтыг тус тус үндэслэн “Монголын Хуульчдын холбооны гишүүний татварын журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тогтоолыг 2014 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ

Д.БАТСҮХ

## МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ГИШҮҮНИЙ ТАТВАРЫН ЖУРАМ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

#### 1.1 дүгээр зүйл.Журмын зорилт

1.Энэ журмын зорилт нь Монголын Хуульчдын холбоо /цаашид “Холбоо” гэх/-ны гишүүний татвар төлүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 1.2 дугаар зүйл.Гишүүний татвар

1.Хуульчдын холбооны гишүүнээр элсэж, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэмд заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, гишүүний бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсны төлөө гишүүнээс Холбоонд төлж байгаа мөнгөн хөрөнгийг “гишүүний татвар” гэнэ.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ ГИШҮҮНИЙ ТАТВАРЫН ХЭМЖЭЭ, ТАТВАР ТӨЛӨГЧ

#### 2.1 дүгээр зүйл.Гишүүний татварын хэмжээ

1.Гишүүний татварын хэмжээг Хуульчдын Их хурал тогтооно.

#### 2.2 дугаар зүйл.Гишүүний татвар төлөгч

1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэм, Холбооны бүртгэлийн нэгдсэн журамд заасны дагуу хуульчдын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн хуульч “гишүүний татвар төлөгч” байна.

### ГУРАВДУГААР БҮЛЭГ ГИШҮҮНИЙ ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ

#### 3.1 дүгээр зүйл.Гишүүнд татварын хөнгөлөлт үзүүлэх

1.Холбоо, гишүүний эрүүл мэнд болон хүндэтгэн үзэх бусад шалтгааныг харгалзан дор дурдсан татварын хөнгөлөлтийг үзүүлнэ:

- 1.1.гишүүний татвар төлөх хугацааг хойшлуулах;
- 1.2.гишүүний татварыг хэсэгчлэн төлүүлэх;
- 1.3.гишүүний татварыг 1 жил хүртэлх хугацаанд 50 хувиар бууруулах.
- 1.4.Хөгжлийн бэрхшээлтэй хуульчийг гишүүний татвараас 50 хувь хөнгөлнө.

/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хурлын 44 дүгээр тогтоолоор нэмж оруулсан./

Тайлбар: Энэ журамд заасан “хөгжлийн бэрхшээлтэй” гэдгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д зааснаар ойлгоно.

2.Гишүүний гаргасан хүсэлтийг үндэслэн Тамгын газрын даргын шийдвэрээр гишүүний татвар төлөх хугацааг зургаан сар хүртэл хугацаагаар хойшлуулж болно.

3.Гишүүний хүсэлтээр татварыг тодорхой хугацаа, хэмжээгээр хуваан төлүүлэхийг “хэсэгчлэн төлүүлэх” гэнэ.

4.Энэ зүйлийн 1.1, 1.2-т заасан хөнгөлөлтийг нэг жилээс дээш хугацаагаар гадаад улсад суралцах, ажиллахаар болсон, эсхүл бага насны хүүхэд болон хүнд өвчтэй гэр бүлийн гишүүн, хамаатан саданг 6 сараас дээш хугацаагаар асрахаар болсон тохиолдолд, 1.3-т заасан хөнгөлөлтийг эрүүл мэндийн улмаас хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй болсон тохиолдолд тус тус эдлүүлнэ.

### **3.2 дугаар зүйл.Гишүүний татвараас чөлөөлөх**

1.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуульч мэргэжлийн үйл ажиллагааг нэг жилээс дээш хугацаагаар эрхлэх боломжгүй болсон гишүүний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсний үндсэн дээр гишүүний татвар төлөх үүргээс чөлөөлнө.

2.Хууль, Холбооны дүрэмд заасан үндэслэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гишүүний татвараас чөлөөлнө.

3.Мэргэжлийн хариуцлагын хорооны шийдвэрээр хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь түдгэлзсэн гишүүнд энэ зүйлийн 2 дахь заалт хамаарахгүй.

*//Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хурлын 44 дүгээр тогтоолоор хүчингүйд тооцсон./*

4.70-аас дээш настай хуульчийг татвараас чөлөөлнө.

*//Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хурлын 44 дүгээр тогтоолоор нэмж оруулсан./*

### **3.3 дугаар зүйл.Гишүүн татварын хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх хүсэлт гаргах**

1.Хуульч, гишүүний татварын хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх өргөдлөө батлагдсан маягтын дагуу Тамгын газарт бичгээр гаргах бөгөөд түүнд дараах баримт бичгийг хавсаргана:

- 1.1.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хуулбар;
- 1.2.хүндэтгэн үзэх шалтгаанаа нотолсон баримт.

2.Энэ зүйлийн 1-д заасан өргөдлийн маягыг Тамгын газрын дарга батална.

### **3.4 дүгээр зүйл.Хүсэлтийг хянан шийдвэрлэх**

1.Тамгын газар энэ журмын 3.3 дугаар зүйлд заасан хүсэлтийг хүлээн авч дор дурдсан ажиллагааг явуулна:

1.1.хүсэлтийн үндэслэл, түүнийг нотолсон баримттай танилцаж, тухайн хүсэлт нь үндэслэлтэй гэж үзвэл татварын хөнгөлөлт үзүүлэх шийдвэр гаргах, татвараас чөлөөлөгдөх тухай хүсэлтийг Ерөнхийлөгчид танилцуулах;

1.2.хүсэлт нь үндэслэлгүй гэж үзвэл, түүнийг шийдвэрлэх боломжгүй болохыг тухайн хүсэлт гаргагчид мэдэгдэх.

2.Татварын хөнгөлөлт үзүүлэх шийдвэрийг Тамгын газрын дарга, татвараас чөлөөлөх шийдвэрийг Ерөнхийлөгч тус тус гаргана.

3.Энэ зүйлийн 1-д заасан ажиллагааг хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан явуулна.

### **3.5 дугаар зүйл.Хугацаа тоолох**

1.Татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөгдөх хугацааг, хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх шийдвэр гарсан өдрөөс эхлэн тооцно.

2.Татварын хөнгөлөлт үзүүлэх шийдвэрт хөнгөлөлт үзүүлэх хугацаа дуусах өдрийг тодорхой заана.

3.Татвараас чөлөөлөх хугацаа нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сэргээсэн өдөр хүртэлх хугацаанд үргэлжилнэ.

### **3.6 дугаар зүйл.Татварын хөнгөлөлт үзүүлсэн, татвараас чөлөөлсний үр дагавар**

1.Татварын хөнгөлөлт үзүүлсэн нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэм заасан гишүүний эрхийг хязгаарлах, үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

2.Гишүүнийг татвараас чөлөөлсөн хугацаанд хуульч нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Холбооны дүрэмд заасан гишүүний эрх, үүргийг хэрэгжүүлэхгүй.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГИШҮҮНИЙ ТАТВАР ТӨЛӨХ, ТАЙЛАГНАХ**

### **4.1 дүгээр зүйл.Гишүүний татвар төлөх**

1.Гишүүн, татвараа сар бүрийн эхний долоо хоногт багтаан Холбоонд төлөх бөгөөд татвар төлсөн баримтад гишүүний бүртгэлийн болон регистерийн дугаар, овог, нэрээ тодорхой, гаргацтай тэмдэглэсэн байна.

2.Гишүүн татвараа зохих хугацаанд төлснөө өөрөө нотлох ба Тамгын газрын шаардсанаар татвар төлсөн тухай тайлангаа бичгээр гаргаж өгнө.

3.Татварыг зөвхөн бэлэн бус хэлбэрээр төлнө.

## **ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **5.1 дүгээр зүйл.Гишүүний татварын хөнгөлөлт үзүүлсэн, татвараас чөлөөлсөн шийдвэрийг цуцлах**

1.Дор дурдсан үндэслэлээр татварын хөнгөлөлт үзүүлсэн, татвараас чөлөөлсөн шийдвэр гаргасан этгээд шийдвэрээ цуцлана:

1.1.Татварын хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх хүсэлтэд дурдсан үндэслэл, түүнд хавсаргасан баримт хуурамч болох нь илэрсэн;

1.2.Татвараас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан хуульч нь гишүүний татвараас чөлөөлөгдсөн хугацаанд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн.

2.Энэ зүйлд заасан үндэслэлээр татварын хөнгөлөлт үзүүлсэн, татвараас чөлөөлсөн шийдвэр цуцлагдсан бол мэргэжлийн дүрэмд заасан хариуцлага хүлээлгэснийг үл харгалзан төлөх ёстой байсан татварыг нөхөн төлүүлнэ.

### **5.2 дугаар зүйл.Журам зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

1.Энэ журмыг зөрчсөн гишүүний зөрчлийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 64.5.3-т заасан журмын дагуу Мэргэжлийн хариуцлагын хороогоор шийдвэрлүүлнэ.

[/Энэ хэсгийг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/](#)

### **5.3 дугаар зүйл.Журам хүчин төгөлдөр болох**

1.Энэ журмыг 2014 оны 1 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.